

Өмнөговь аймгийн хүн амын эрүүл мэнд, эмнэлгийн тусламж

үйлчилгээний товч мэдээлэл

/2019 оны 5 сарын байдлаар/

	Үзүүлэлт	<u>БӨЭТ</u>	Сумдын эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Цэргийн анги	Нийт аймгийн дүн
1	Нийт үзлэг	54931	51952	38897	18657	1599	166036
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	22706	18654	14990	1782	1372	59504
3	Идэвхтэй хяналтын үзлэг	5037	9598	8264	1155		24054
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	13548	10750	6306	4096	228	34928
5	Нийт төрөлт	513	128				641
6	Хэвтэн эмчлүүлэгчид	3545	2279		1010	15	6849
7	Нас баралт	16	73	48			137

1. Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 166036 хүнд үзлэг шинжилгээ хийсний 50.3%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
2. Ортой эмнэлгүүдэд нийт 6849 хүнийг 45612 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.6 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
3. 5 сарын байдлаар 34928 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6775 тохиолдлоор өссөн байна.
4. Эхний 5 сарын байдлаар 505 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба осол гэмтлээр 25 хүн нас барсан нь өнгөрсөн оноос өвчлөл 71 тохиолдлоор буурч, осол гэмтлийн нас баралт 5-р тохиолдлоор өссөн байна. Осол гэмтлээр нас барагсдын 32%/8/нь амиа хорлож/Гт-1,Мо-1,Мн-1,Сэ-1,Хх-1,Хб-1,Эу-2/ 24%/6/нь зам тээврийн осол,/Но-2,Сэ-1,Хү-1,Эх-1,Эу-1/, 40%/10/ нь бусад ослоор/хөлдсөн-7-Сэ-2,Хб-1,Хх-1,Цц-2,Эх-1,архины хордлого-Гт-1,Эх-1,зодуулсан-Но-1/ 4%/1/бусдад хорлогдсон-/Но-1/ тус тус эндсэн байна. Осол гэмтлээр нас барагсадын 84% нь эрэгтэй хүмүүс эндсэн байна. Мөн ослоор эндэгсдийн 76% нь эмнэлгийн ямар нэг тусламж авч чадаагүйн дээр эмнэлэгт нас барсан 50%/6/ хүний /өөрийгөө буудсан-1, хөлдсөн-1,бусдад хорлогдсон-1, архины хордлого-1 нийт-4 хүн/хүнд гэмтлийн улмаас хоног болоогүй нас барсан байна. Нийт осол гэмтлийн нас баралт:Гт-2/амиа хорлосон-1,хөлдсөн-1/,Мо-1/амиа хорлосон-1/,Мн-1/амиа хорлосон-1/,Но-2/зам тээврийн осол-2/,Сэ-4/хөлдсөн-2,амиа хорлосон-1,зам тээвэр-1/,Хх-2/амиа хорлосон-1,хөлдсөн-1/,Хб-2/амиа хорлосон-1,хөлдсөн-1/,Хү-1/зам тээврийн осол-1/,Эх-2/архинд хордсон-1,хөлдсөн-1/Эу-5/амиа хорлосон-2,зам тээвэр-1, хөлдсөн-2/

5. Оны гарсаар 137 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 18,2% нь осол гэмтлээр, 20,4% нь хорт хавдраар 8% нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт/Бо-1,Хх-3,Цо-2,Шб-3,Өо-1,Эх-1/ зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 8% /Хб-5,Гт-4,Мн-1,Бг-1/нь нярай үеийн эмгэгийн улмаас нас барсан байна.
6. Нялхсын эндэгдлийн 13/Гт-4,Хб-5,Цц-1,Мн-1,Эх-1,Бг-1/тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 20,2 байна.
7. Түргэн тусламжийн 5552 дуудлагад явж үйлчилсний 814/14.6%/ нь алсын дуудлага, 267/4,8%/ нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 95,8% -д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна .
8. 5 сард 4620 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 62,2% эзэлж байгаа нь хангалтгүй байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 8 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,1%-г эзэлж байна.
9. Нийт 641 эх төрж 642 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 22 төрөлтөөр хүн амын төрөлт өссөн байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна. Нийт төрөлтийн 6% охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт байна./Бо-1,Бу-2,Гт-3,Мн-3,Но-2,Сэ-1,Хб-1,Хх-3,Хү-1,Цц-6,Шб-3,Өо-9,Эх-4,Бг-1/.
10. 5 сарын байдлаар 276 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 430,5 байгаа нь өнгөрсөн оноос 1,3% буурсан үзүүлэлт байна.Өсвөр насны охидын үр хөндөлт 5,8%/Бд-1,Бу-2,Мо-1,Но-2,Сэ-1,Хб-3,Хх-1,Хү-1,Шб-1,Өо-1,Эх-1,Бг-1/ байна.
11. Он гараад 162 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 211 тохиолдлоор буурсан байна. Нийт халдварт өвчний 24.7%-г салхинцэцэг, 9.8%-г улаанэсэргэнэ өвчин, 48.1%-г БЗДХ өвчин тус тус эзэлж байна.
12. ЭЭСангуудад нийт 8139 жор ирсний 50.1%/4081/нь ЭМДаатгалын, 0,1%/9/ мансууруулах эмийн, 2% /164/ сэтгэц нөлөөт эмийн, 47.7% /3885/ нь энгийн эмийн жор байсан ба 1% /87/нь алдаатай жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 80.6% байна.
13. БОЭТөвд 16 эндэгдэл тохиолдож 4 эндэгдэлийг онош тодорхой, өндөр настан, ар гэрийн хүсэлтээр гэсэн шалтгаанаар задлан шинжилгээнд хамруулаагүй ба задлан шинжилгээний хувь 75% тай байна. Үндсэн оношийн зөрөө 0%.

Мэдээлэл бэлтгэсэн: ЭМГ-н статистикч Б Мидэрсүрэн , Д. Гантогтох